



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 20 өдөр

Дугаар А/106

Хэрлэн сум

Газар эзэмших эрхийн  
гэрчилгээг шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай нотлох баримтыг бүрдүүлэн гаргасан өргөдлийн дагуу иргэн Х.Эрхэмбаатарын эзэмшлийн Хэрлэн сумын 5 дугаар баг (Өндөрхаан), Тариаланчид гудамжинд байрлах, үйлдвэрлэлийн зориулалттай 2867 м<sup>2</sup> газрыг иргэн Б.Хувцагаанд 49 жилийн хугацаатайгаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2.Б.Хувцагааны эзэмшил газрын кадастрын зураглалыг хавсралтаар баталсугай.

3.Газар эзэмших эрхийн гэрчилгээг олгон гэрээ байгуулж, гэрээний биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Сүнгээ)-д үүрэг болгосугай.

4.Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг иргэн Б.Хувцагаанд үүрэг болгосугай.

5.Энэхүү захирамжийг гаргасантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2012 оны А/317 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ